**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/650 Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын багш нарын 53 дахь баярын өдрийг тохиолдуулан Боловсролын салбарт хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Буянт сумын Цэцэрлэгийн туслах тогооч Х.Гүлбарчин, сахиул Х.Ганхуяг, Дөргөн сумын Цэцэрлэгийн багш Э.Гэрэлээ, Манхан сумын Цэцэрлэгийн багш Д.Уламдэлгэр, Мянгад сумын Цэцэрлэгийн багш Б.Болорсувд, Мөст сумын Цэцэрлэгийн багш М.Нямцэцэг, Цэцэг сумын Цэцэрлэгийн багш Б.Пунсал нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2.Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Х.Гүлбарчин, Х.Ганхуяг, Э.Гэрэлээ, Д.Уламдэлгэр, Б.Болорсувд, М.Нямцэцэг, Б.Пунсал нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх сумдын Цэцэрлэгийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/650-Da 02 03195